

**Монголын зохиолч, хөгжмийн зохиолч,
нийтлэгчдийн нийгэмлэг (МОСКАП)-ийн
хөгжмийн бүтээл ашиглуулах төлбөрийн хэмжээ**

Энэхүү төлбөрийн хэмжээ нь Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэгийн гишүүдийн болон (МОСКАП)-тай зохиогчийн эрхийг харилцан төлөөлөх хамтын ажиллагааны гэрээтэй 24 орны хөгжмийн эрхийн хамтын удирдлагын байгууллагуудын гишүүдийн хөгжмийн бүх төрлийн бүтээлийг ашиглахад мөрдөх зохиогчийн эд хөрөнгийн онцгой эрхийн төлбөрийн хэмжээ бөгөөд хамаарах эрх эзэмшигчид буюу фонограм бүтээгч бичлэгийн лейбл студи, гүйцэтгэгч уран бүтээлчдийн эрхийн төлбөр ороогүй болно.

Хөгжмийн бүтээл ашиглалтаас зохиогчийн хүртэх төлбөрийн хувь хэмжээг тогтоохдоо CISAC (International Confederation of Societies of Authors and Composers)-Олон улсын зохиолч, хөгжмийн зохиолчдын нийгэмлэгүүдийн холбооны бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг тогтоох аргачлалаар тооцоолж, CISAC-ийн гишүүн Ази номхон далайн орнуудын хөгжмийн нийгэмлэгүүдийн бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээ, лицензийн төлбөр хураан төвлөрүүлэх журам ба гишүүдэд хуваарилах журмыг удирдлага болгон боловсруулав.

Мөн оюуны өмч зохиогчийн эрхийг дээдлэх соёлыг хэрэглэгчдэд төлөвшүүлэх, хөгжмийн бүтээлийн зохиогч, бүтээлийг ашиглах лиценз эзэмшигч ба нийт хэрэглэгчийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангахийн зэрэгцээ хамтын удирдлагын байгууллагын тогтвортой үйл ажиллагааг үл доголдуулахыг зорьж, хөгжмийн бүтээлийг бизнесийн гол үндсэн хэрэглэгдэхүүнээ болгосон энтертэйнмент шоу бизнес, хөгжмийн бүтээл түгээлтийн сүвгүүд болон медиа контент үйлдвэрлэл эрхлэгчдийн орлого, үзэгчдийн тоо, хандалт, үйл ажиллагааны цар хүрээг судалсны үндсэн дээр боловсруулсан болно.

Энэхүү тариф нь хөгжмийн үгтэй болон үггүй бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигч: дотоод гадаадын хөгжмийн зохиолч, шүлгийн зохиолчид олгох зохиогчийн механик эрхийн ба олон нийтийн гүйцэтгэлийн эрхийн төлбөрийн хэмжээ юм.

МОСКАП нь хөгжмийн бүтээлийг видео контент, кино, видео тоглоом, реклам зар сурталчилгаа зэрэг дүрст бүтээлд хөгжмийг ашиглах синхрон эрхийг удирдан зохицуулдаггүй тул уг ангилалын төлбөрийн хэмжээг зохиогчид өөрсдөө кино ТВ видео продакшнтай шууд тохирох эрхийг зохиогчид өөрт нь нээлттэй үлдээлээ. Мөн дуурь балет драмын жүжгийн хөгжмийн зохиогчийн эрхийг манай нийгэмлэг төлөөлөхгүй болно.

Жич: Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийг ашиг олох зорилгоор зохиогчийн эрхийн хуулийн 19.5 т заасан нөхцлөөр ашиглах тохиолдолд Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэгийн бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг мөрдөж, бүтээл ашиглагч тал нийгэмлэгтэй лицензийн гэрээ байгуулан бүтээлийг ашиглана.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ОЛОН НИЙТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЭРХИЙН ТӨЛБӨР

1.1 Олон нийтэд тоглуулах (public performance right)

Амьд тоглолт, фестивал наадам, шоу эвент, спорт урлагийн бүхий л арга хэмжээний тасалбар борлуулж ашиг олж буй тоглолтын промоутер ерөнхий зохион байгуулагчдаас бүтээлийг **нийтэд тоглуулах** зохиогчийн эрхийн төлбөрийг авна.

Мөн тасалбаргүй олон нийтэд хаалттай арга хэмжээг захиалагч, зохион байгуулагч аж ахуйн нэгж хувь хүн төлнө. Харин найз нөхөд, гэр бүлийн хүрээний хувь хүний одонгийн найр, хүрим, үсний найр, насны ой, төрсөн өдрийн арга хэмжээ болон хүмүүнлэгийн арга хэмжээнээс бүтээл ашиглалтын төлбөр авахгүй.

№	Төрөл	Тариф	Тайлбар
1.1.1	Амьд тоглолт, хөгжмийн наадам, DJ set	(Борлуулсан тасалбарын тоо $\times$ тасалбарын үнэ) $\times$ 3% зохиогчийн эрхийн төлбөр $\div$ нийт тоглогдсон бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо $\times$ арга хэмжээ болсон тоо буюу давтамж <i>Лиценз хүсэгч нь дуу хөгжмийг зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй нийтэд тоглуулахын тулд тоглолтын хөтөлбөрийг урьдчилан ирүүлж, MOSCAP бүтээлийн урын сантай тулгаж, лицензийн гэрээг арга хэмжээнээс өмнө байгуулсан байх үүрэгтэй</i>	Тасалбарын дундаж үнийг ангилал бүрээр борлуулах тасалбарын тоо бүхий жагсаалтаар дундажлан тооцно. Борлуулсан тасалбарын тоог мэдэх боломжгүй тохиолдолд тухайн арга хэмжээний нийт багтаамжийн 60-70 хувиар тооцно.
1.1.2	Хөгжмийг туслах үүргээр ашиглах Соёлын олон төрөлт шоу арга хэмжээ Загварын шоу, цирк, бүжгийн тоглолт тэмцээн наадам, уран гулгалт, яруу найргийн наадам хөгжимт уншлага, соёл спортын арга хэмжээ, хошин шог, комеди театр, варьетэ шоу зэрэг (Нийт хөтөлбөрийн 30-иас бага хувьд хөгжмийн бүтээлийн амьд тоглолт орсон)	(Борлуулсан тасалбарын тоо $\times$ тасалбарын үнэ) $\times$ 1% $\div$ нийт бүтээлийн тоо $\times$ MOSCAP дууны тоо <i>Тасалбарын дундаж үнийг ангилал бүрээр борлуулах тасалбарын тоо бүхий жагсаалтаар дундажлан тооцно.</i> <i>Борлуулсан тасалбарын тоог мэдэх боломжгүй тохиолдолд тухайн арга хэмжээний нийт багтаамжийн 60 хувиар тооцно.</i>	
1.1.3	Тасалбар борлуулалтгүй олон нийтэд нээлттэй өдөрлөг, цэнгээнт үйл	1 дууны бүтээл -200,000 төгрөг $\times$ тоглогдсон MOSCAP бүтээлийн тоо	

	ажиллагаанд арын дэвсгэр хөгжим тоглуулах ба амьд тоглолт	Цөөхүүл ба гоцлол, Найрал хөгжмийн 1 бүтээл 300,000₮ × тоглогдсон MOSCAP бүтээлийн тоо Бүжиг, цирк, уран гулгалт, уран уншлага, драмын үзүүлбэрийн арын дэвсгэр хөгжим- 1 бүтээл 100,000 төгрөг
1.1.4	Тасалбар борлуулалтгүй, олон нийтэд хаалттай арга хэмжээ: Хүлээн авалт, тоглолт, ойн баяр, шинэ жил, семинар, өдөрлөг, үдэшлэг (Хувийн ойр дотно хүрээллийн төрсөн өдөр хурим, үсний найр хамаарахгүй)	1 дууны бүтээл -200,000 төгрөг × тоглогдсон MOSCAP бүтээлийн тоо Цөөхүүл ба гоцлол, Найрал хөгжмийн 1 бүтээл 300,000₮ × тоглогдсон MOSCAP бүтээлийн тоо Бүжиг, цирк, уран гулгалт, уран уншлага, драмын үзүүлбэрийн арын дэвсгэр хөгжим- 1 бүтээл 100,000 төгрөг

1.2 Телевиз, радио, IPTV-ээр олон нийтэд дамжуулах (Broadcasting)

Өргөн нэвтрүүлэг болон олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хөгжмийн үгтэй болон үггүй бүтээлийг эфирт ашиглах, тэдгээрийг олон нийтэд нэгэн зэрэг дамжуулахдаа дараах зохиогчийн эрхийн төлбөрийг хураан авна.

№	Төрөл	Тариф
1.2.1	Телевиз (Нэвтрүүлгүүдийн дэвсгэр хөгжим, гол сэдэв болсон хөгжим, концерт тоглолтууд)	<i>Ерөнхий тариф:</i> 1. МҮОНРТ: Улсаас баталсан жилийн төсвийн 0.1% 2. Өргөн нэвтрүүлгийн 18 ТВ 21.6 сая₮жилд/сард 1.8сая₮ 3. Өргөн нэвтрүүлгийн орон нутгийн ТВ: 2 сая ₮ жилд 4. Арилжааны ТВ УБ хот: 3 сая ₮ жилд/сард 250.000₮ 5. Арилжааны ТВ Орон нутаг: 1.2 сая ₮ жилд 6. TB shop жилийн нийт орлогын 0,3%-г авна <i>Албан ёсны эрхтэй хөгжмийн шоу нэвтрүүлэг тусдаа тарифтай:</i> Ковер тоглуулах: Хөгжмийн бүтээлийн анхны бичлэг, анхны гүйцэтгэгч уран бүтээлчээс өөр хүн бүтээлийг шинээр дуу бичлэг ба дүрс бичлэг хийн ашиглаж байгаа тул хуулбарлах эрхийн ба синхрон эрхийн төлбөр төлнө. Хуулбарлах эрх: 1 дууны шинэ фонограм 1 сая төгрөг Синхрон эрх: 1 дууны видео бүтээх 1 сая төгрөг Нийтэд тоглох- 1 дуу 500,000 төгрөг

1.2.2	Кабелийн ТВ	• өмнөх жилийн орлогын 0.1%
1.2.3	Интернэт протоколд суурилсан IPTV ба Хиймэл дагуулын Sat TV	• өмнөх жилийн орлогын 0.1%
1.2.4	Интернэтд суурилсан ОТТ Платформууд: олон суваг, VOD контент дамжуулах үйлчилгээ (ORI, Look TV, VOO, Go+)	• өмнөх жилийн орлогын 0.1%
1.2.5	ФМ AM Радио	<i>Олон нийтийн радио:</i> • Улсаас баталсан жилийн төсвийн 0.1% <i>Хөгжмийн радио:</i> • 3,000,000₮/жилд 250,000₮/сард <i>УБ хотын радио:</i> • 2,400,000₮/жилд 200,000₮/сард Хөдөө орон нутгийн радио 1,200,000₮/жилд 100,000₮/сард

1.3 Бизнесийн орон зайд нийтийн үйлчилгээний газарт **олон нийтэд бичлэгээр дамжуулах, тоглуулах** зохиогчийн эрхийн төлбөр

№	Төрөл	Тариф
1.3.1	Ресторан, хөгжмийн лаунж, паб, баар (Restaurant, Bar, Lounge, Buffet, pub, restobar) (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	<i>Талбайн хэмжээгээр:</i> • 60мкв -99мкв 60,000₮/сар бүр • 100мкв-150 мкв 80,000₮/сар бүр • 151-200мкв 100,000 ₮/сар бүр • 200-250 мкв бол 120,000₮/сар бүр Үүнээс дээш 50 мкв тутам сарын 20,000₮ нэмэгдэн тооцогдоно <i>Хэрэв амьд хөгжмийн тоглолт зохион байгуулдаг бол дээрх тарифыг 2 дахин үржүүлэн тооцно.</i> Эсвэл тухайн газарт болж буй тоглолт бүрд 800,000 төгрөг төлнө. <i>LED дэлгэц дээр хөгжмийн бүтээл тоглуулагддаг бол 1 дэлгэц жил бүр 200,000 төгрөг нэмж тооцно</i>
1.3.2	Бүжиглэх зориулалттай Шөнийн клуб, босоо үйлчилдэг баар Нийтэд тоглуулах эрхийн төлбөр	<i>Талбайн хэмжээгээр:</i> • 70мкв түүнээс бага бол 80,000₮/сар бүр • 71мкв -99мкв 100,000₮/сар бүр • 100мкв-130 мкв 130,000₮/сар бүр • 131-165мкв 180,000 ₮/сар бүр • 166-200 мкв бол 220,000₮/сар бүр Үүнээс дээш 30 мкв тутам сарын 30,000₮ нэмэгдэн тооцогдоно

		100 м ² хүрэхгүй тохиолдолд, нэг метр квадрат тутамд 2500₮ сар бүр
1.3.3	Кофе шоп, алкахолгүй ундааны зүйлс борлуулдаг газрууд (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	<i>Талбайн хэмжээгээр</i> 30-99 мкв жилд 360,000₮/жилд 100-150 мкв 500,000₮/жилд 150-200 мкв 600,000₮/жилд Үүнээс дээш 50 мкв тутамд жилийн 100,000₮ нэмэгдэн тооцогдоно
1.3.4	Караоке баар Нийтэд тоглуулах эрхийн төлбөр	Зохиогчийн эрхийг хүндлэн сайн дураар www.moscap.mn вэбсайтаар хүсэлт илгээн онлайнаар лицензийн төлбөр төлсөн эсвэл тоолууртай караоке тоглуулагч хэрэглэсэн тохиолдолд - УБ хотын төвийн караоке бар тоглуулагч/өрөө бүрээс 30,000₮/ сард - УБ хотын захын караоке бар тоглуулагч/өрөө бүрээс 20,000₮/ сард - Хөдөө орон нутгийн караоке бар тоглуулагч/өрөө бүрээс 20,000₮/ сард <i>Нэмэлт тайлбар: 4 хүртэл өрөөтэй бол дээрх тарифийг баримтлана. 5-10 өрөөтэй бол дээрх тарифын 10 хувиар хөнгөлөлт үзүүлнэ. 11 ба түүнээс дээш өрөөтэй бол дээрх үнийн 20 хувиар хөнгөлнө. Бүтэн жилээр төлбөл 30 хувиар хөнгөлөлт үзүүлнэ.</i> Караоке бааранд MOSCAP ажилтан очиж, албадан гэрээ байгуулж төлбөр нэхэмжлэх тохиолдолд Өрөөний талбайн хэмжээгээр 10 мкв хүртэлх өрөө – 35'000₮/нэг өрөө, сард 11-40 мкв өрөө -50'000₮/нэг өрөө, сард 40мкв-аас том өрөө бол 65,000₮/нэг өрөө, сард 50 мкв с том Лобби хүлээлгийн заал 200,000₮/ жилд - Нийтийн танхимын тоглуулагч бүрээс 240,000₮/ жилд <i>Нэмэлт тайлбар: 5-10 өрөөтэй бол дээрх тарифын 10 хувиар хөнгөлөлт үзүүлнэ. 11-ээс дээш өрөөтэй бол 30% хямдралтай</i>
1.3.5	Кино театр (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	Жилийн нийт орлогын 0,2% Хэрэв жилийн орлогын 0,2% нь жилийн төлбөрийн доод хэмжээнээс бага байвал дараах төлбөрийн доод хэмжээг мөрднө. Улаанбаатар хот: 100 хүртлэх суудал: 1,000,000₮/ жилд - Дараагийн 100 суудал тутамд: 600,000₮/ жилд - Нэмэлт 1 суудал тутамд: 4,000₮/ жилд Хөдөө орон нутаг 100 хүртлэх суудал: 600,000₮/ жилд - Нэмэлт 100 суудал тутамд: 200,000₮/ жилд
1.3.6	Агаарын тээврийн компани (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	<i>Зорчигдын тоо:</i> 1'750₮ (\$0.50)/олон улсын нислэгийн зорчигч бүрээс 1,050₮ (\$0.30)/орон нутгийн зорчигч бүрээс

1.3.7	Хот хоорондын тээврийн компани	1 автобус 80’000₮/ жилд																
1.3.8	Нийтийн тээврийн компани	1 автобус 30’000₮/ жилд																
1.3.9	Төмөр зам зорчигч тээврийн үйлчилгээ	- Галт тэрэгний 1 чиглэл 150,000₮ * жилийн давтамж - Караоке тоглуулагчнаас 300’000₮ * жилийн давтамж																
1.3.10	Зорчигч хүлээлгийн танхим (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	1мкв 500₮ жилд																
1.3.11	Фитнесс (нийтэд дамжуулах эрхийн төлбөр)	м² хэмжээ: 1-300м² - 600,000₮/жилд + 50м² тус бүр – 200,000₮/жилд 50 инч хүртэлх хэмжээтэй ЛЕД дэлгэц бүрээс жилийн 250,000₮ 50 инчээс том дэлгэцнээс жилийн 500,000₮																
1.3.12	Үсчин Гоо сайханы салон болон спа, массаж, wellness center (дуу авианы эмчилгээ, хөгжимт бясалгал)	м² хэмжээ: 40-100м² - 200’000₮/жилд 101-150м² - 300’000₮/жилд +10м² тус бүр - -20’000₮/жил бүр эсвэл Мкв тутам Жилд 3,000 төгрөг ба төлбөрийн доод хэмжээ жилд 200,000₮																
1.3.13	Худалдааны төв жижиглэн худалдааны дэлгүүр (Shopping mall, Retail store)	Багц үнэ: 0-200м² - 300’000₮/жилд - Нэмэлт 1 мкв тутамд -2000₮/жилд Талбайн хэмжээг нарийвчлах бол: м² нэгжийн үнэ <table><tr><td>≤1500 м²</td><td>1500₮ жилд</td></tr><tr><td>1501–5000 м²</td><td>1400₮ жилд</td></tr><tr><td>5001–10000 м²</td><td>1275₮ жилд</td></tr><tr><td>10001–30000 м²</td><td>1125₮ жилд</td></tr><tr><td>30001–50000 м²</td><td>950₮ жилд</td></tr><tr><td>50001–100000 м²</td><td>750₮ жилд</td></tr><tr><td>>100000 м²</td><td>500₮ жилд</td></tr></table>	≤1500 м²	1500₮ жилд	1501–5000 м²	1400₮ жилд	5001–10000 м²	1275₮ жилд	10001–30000 м²	1125₮ жилд	30001–50000 м²	950₮ жилд	50001–100000 м²	750₮ жилд	>100000 м²	500₮ жилд		
≤1500 м²	1500₮ жилд																	
1501–5000 м²	1400₮ жилд																	
5001–10000 м²	1275₮ жилд																	
10001–30000 м²	1125₮ жилд																	
30001–50000 м²	950₮ жилд																	
50001–100000 м²	750₮ жилд																	
>100000 м²	500₮ жилд																	
1.3.14	Супермаркет Түргэн үйлчилгээний дэлгүүр	Талбайн хэмжээ: м² ийн нэгж үнэ <table><tr><td>≤200 м²</td><td>м² үнэ 1500₮ жилд</td></tr><tr><td>201–500 м²</td><td>м² үнэ 1300₮ жилд</td></tr><tr><td>501–1000 м²</td><td>м² үнэ 1250₮ жилд</td></tr><tr><td>1001–3000 м²</td><td>м² үнэ 1190₮ жилд</td></tr><tr><td>3001–5000 м²</td><td>м² үнэ 1125₮ жилд</td></tr><tr><td>5001–10000 м²</td><td>м² үнэ 1050₮ жилд</td></tr><tr><td>10001–20000 м²</td><td>м² үнэ 950₮ жилд</td></tr><tr><td>>20001 м²</td><td>м² үнэ 900₮ жилд</td></tr></table>	≤200 м²	м² үнэ 1500₮ жилд	201–500 м²	м² үнэ 1300₮ жилд	501–1000 м²	м² үнэ 1250₮ жилд	1001–3000 м²	м² үнэ 1190₮ жилд	3001–5000 м²	м² үнэ 1125₮ жилд	5001–10000 м²	м² үнэ 1050₮ жилд	10001–20000 м²	м² үнэ 950₮ жилд	>20001 м²	м² үнэ 900₮ жилд
≤200 м²	м² үнэ 1500₮ жилд																	
201–500 м²	м² үнэ 1300₮ жилд																	
501–1000 м²	м² үнэ 1250₮ жилд																	
1001–3000 м²	м² үнэ 1190₮ жилд																	
3001–5000 м²	м² үнэ 1125₮ жилд																	
5001–10000 м²	м² үнэ 1050₮ жилд																	
10001–20000 м²	м² үнэ 950₮ жилд																	
>20001 м²	м² үнэ 900₮ жилд																	
1.3.15	Тавилга, гэр ахуйн барааны дэлгүүр	Үйл ажиллагааны талбай Төлбөр (₮/м²/жил) ≤3000 м² 900₮ жилд																

		3001–10000 м ² 750₮ жилд 10001–20000 м ² 600₮ жилд >20001 м ² 500₮ жилд
1.3.16	Авто 4S дэлгүүр	1м ² нэгж үнэ 750₮ жилд
1.3.17	Дуу, дүрс бичлэгийн бүтээгдхүүний дэлгүүр CD пянз, видео кассет, DVD	• м² нэгж үнэ 8000₮ жилд • ЛЕД дэлгэц бүр жилд 100,000₮
1.3.18	Богино хугацаат үзэсгэлэн худалдаа, экспо арга хэмжээ	• Үзэсгэлэнгийн талбайн түрээсийн төлбөрийн 1% эсвэл • Арын дэвсгэр хөгжим бичлэгт 100мкв тутамд өдрийн 60,000₮ • Амьд тоглолттой бол 100мкв тутамд өдрийн 100,000 ₮
1.3.19	Зочид буудал, амралтын газар, сувилал	• 4,5 одтой буудлын 1 өрөө 30,000₮ нэг жилд • 3 одтой буудлын 1 өрөө 15,000₮ нэг жилд • 2 од түүнээс доод зэрэглэлийн буудлын 1 өрөө 10,000₮ жилд • 100 хүртэлх суудалтай хурал, сургалт, хэлэлцүүлэг, хүлээн авалтын танхим 500,000₮/жилд(нэмэлт 1 суудал 40,000₮ жилд • 200 мкв хүртэлх Лобби, Ресепшн, 150,000₮ жилд нэмэлт мкв тутамд 600₮ жилд Энтертэйнмент орон зай: караоке, фитнесс, спа массаж, гоо сайхны салон, ресторан, лаунж кофе шоп тусдаа ангилал бүрийн тарифаар бодогдоно.,
1.3.20	Оффисын төв барилга	• Цахилгаан шат бүр 100,000₮ жилд • ЛЕД дэлгэц бүр жилд 150,000₮ жилд
1.3.21	Боулинг, биллиард	м² хэмжээ: • 1-100м² - 150'000₮/сар бүр • +25м² тус бүр - 10'000₮/сар бүр
1.3.22	Хүүхдийн парк, цэцэрлэгт хүрээлэн	• Тасалбарын орлогын 0.4% • Тасалбаргүй цэцэрлэгт хүрээлэнгийн өсгөгч чанга яригч бүрээс жилд 50,000 төгрөг
1.3.23	Мөсөн гулгалтын талбай	• м² нэгж үнэ 500₮ жилд • ЛЕД дэлгэц бүр жилд 200,000₮
1.3.24	Музей, уран зургийн галлериа	м² хэмжээ: • 1м² - 2'000₮/жилд • +50м² тус бүр - 100'000₮/жилд
1.3.25	Хувийн хэвшлийн албан бус бүжиг, хөгжмийн сургалт	м² хэмжээ: • 200 мкв хүртэл 50,000₮/сар бүр • 200-500м² - 100,000₮/сар бүр • + 50м² тус бүр - 10,000₮/сар бүр эсвэл Суралцагчдын тоо: • 50 хүртэлх сурагчтай - 600,000₮/жилд

		50-100 сурагчтай 800,000₮/жилд 50 суралцагч тутамд 200,000 нэмэгднэ
1.3.26	Банк, шуудан, харилцаа холбооны үйлчилгээний салбарууд	1 мкв тутамд 2500₮ жилд Жилийн хамгийн бага хураамж 250,000 төгрөг жилд

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХУУЛБАРЛАХ ЭРХИЙН ТӨЛБӨР

2.1 Механикаар хуулбарлах эрхийн төлбөр (Mechanical reproduction rights)

Хуулбарлах эрх гэдэг нь эх бүтээлийг биет ба дижитал хэлбэрээр биежүүлэх, хуулбарлах, хэвлэх, хэвлэж буулгах, дуу бичлэг хийх, дүрс бичлэг хийх, өөр форматаар хувирган бичих, зураг авах, дижитал хэлбэрт оруулах зэргээр дахин бүтээхийг хамруулна.

Хөгжмийн бүтээлийг биет хэлбэрээр хувиран олшруулах, хэвлэн нийтэлж борлуулах, цахим орчноор болон тусгай төхөөрөмжид хуулбарлан хадгалж олон нийтэд түгээх, түрээслүүлэн ашиг олох тохиолдолд дараах төлбөрийг төлнө.

Дижитал ашиглалтаас 1. хуулбарлан хадгалж, 2. олон нийтэд дамжуулах зохиогчийн эрхийн төлбөр нийлүүлээд дараах байдлаар авна.

№	Төрөл	Тариф
2.1.1	IPTV ба OTT суурилсан караоке үйлчилгээ (Mkaraoke, Voo karaoke, Go+, ORI дуул багц)	Караоке үйлчилгээний суурь хураамжийн нийт орлогын 12-15% (хуулбарлан хадгалах, олон нийтэд дамжуулах төлбөр нийлсэн)
2.1.2	стриминг: шууд сонсгох үйлчилгээ (M Music app, Sonly app)	- Шууд сонсгох үйлчилгээний суурь хураамжийн Нийт орлогын 12-15% (хуулбарлан хадгалах, олон нийтэд дамжуулах төлбөр нийлсэн) - Хэрэглэгчдэд үнэгүй сонсуулж реклам дамжуулдаг бол зар сурталчилгааны орлогын 16%
2.1.3	Караоке аппликейшн	Караоке үйлчилгээний суурь хураамжийн нийт орлогын 12-15% (хуулбарлан хадгалах, олон нийтэд дамжуулах төлбөр нийлсэн)
2.1.4	Сүлжээгээр дамжуулдаг (communicative) караоке төхөөрөмж	∉ Сүлжээний караоке төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэгч нь караоке төхөөрөмж ашиглаж буй бизнес

	Арилжааны зориулалттай газарт караоке төхөөрөмжийг стриминг хэлбэрээр дамжуулан ашиглах тохиолдолд	эрхлэгчдээс хураан авсан нийт бизнесийн орлогын 10 хувийг төлнө. $\neq$ Нэмэлтээр Караоке бэлдэц болгон хуулбарлах эрхийн төлбөрт 1 дуу тутамд 1,000,000 төгрөг төлнө.
2.1.5	Үүрэн телефон операторын гар утасны дуудлагын үйлчилгээ	• Үйлчилгээний суурь хураамжны нийт орлогын 10% • Мөн нэмэлтээр татан авалтын орлогын 10%

2.2 Хөгжмийн бүтээлийг кассет, пянз, CD, VCD, DVD, IC, CD-ROM хөгжимт тоглоом, дуу захиалах караоке төхөөрөмж, ном хэвлэл сурах бичиг зэрэг биет бүтээгдэхүүнд хуулбарлан олшруулж бүтээгдхүүн үйлдвэрлэж нийтэд түгээх эрхийн төлбөрийн хэмжээг дараах байдлаар тогтоов.

№	Төрөл	Тариф
2.2.1	Пянз, CD, DVD, кассет	• Борлуулах үнийн 6-10% $\times$ нийт хэвлэгдсэн тоо $\div$ бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо <i>Хөгжмийн бүтээлийн үргэлжлэх хугацаа 5 минутаас давсан тохиолдолд, нэмэгдсэн 5 минут тутамд нэг бүтээл нэмсэнтэй тэнцүү ашиглалтын төлбөрийг тооцно (5 минутаас бага хугацааг 5 минутад тооцно). Дүрст бүтээгдхүүн доторх Нэг хөгжмийн бүтээлийн доод үнэ 500,000 төгрөг байна.</i>
2.2.2	USB flash MP3, M4 player Дуун зоолтуур CD rom гэх мэт өндөр багтаамжтай дижитал бүтээгдэхүүний худалдаа	(Борлуулалтын үнийн 10% $\times$ бүтээгдхүүний тоо) $\div$ нийт бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо

2.2.3	Дууны бүтээлийн үгтэй, дүрсжүүлсэн клип бүхий караоке хувилбарыг хуулбарлан түгээх бүх төрлийн караоке тоглуулагчийн үйлдвэрлэл борлуулалт,	1. Борлуулалтын үнийн дүнгээс % тодорхойлбол: - Шинэ тоглуулагчинд бэлдэц хуулбарлах үйлчилгээний борлуулалтын үнийн 10% $\times$ борлуулсан/хуулбарласан тоглуулагчийн тоо) $\div$ нийт хуулбарласан бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо - Караоке баарны хэрэглээнд байгаа хуучин тоглуулагчийн дууны санг сар бүр шинэчлэх үйлчилгээнд 1 шинэ бүтээл хуулбарлах нэгж үнийн 10% $\times$ нийт MOSCAP бүтээлийн тоо $\times$ хуулбарласан тоглуулагчийн тоо (Гэрийн ба хувийн хэрэглээний караоке төхөөрөмжийн борлуулалтын үнэ $\times$ 6% $\times$ борлуулсан төхөөрөмжийн тоо) $\div$ нийт хуулбарласан бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо 2. Хэрэв борлуулсан, хуулбарласан тоглуулагчийн тоог мэдэх боломжгүй бол дууны бүтээлийн - Шинэ дууны бүтээлийн үгтэй, дүрсжүүлсэн клип бүхий караоке хувилбарыг бүтээхэд 1 дуу 1,000,000₮ - Шинэ тоглуулагчинд хуучин караоке бэлдэцийг бөөнөөр хуулбарлахад 1000 дуу тутамд 1,000,000₮/сард
2.2.3	Дуут ном, дуут тоглоом	Борлуулалтын үнийн 6% $\times$ нийт үйлдвэрлэсэн тоо
2.2.4	Хөгжмийн нот, дууны үг ая хэвлэн нийтлэж нийтэд түгээх	Борлуулалтын үнийн 15 % $\times$ нийт хэвлэгдсэн тоо $\div$ нийт бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо Хэрэв үнэ тодорхойгүй бол зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүний үнэд тулгуурлан тооцно. Дээрх аргаар бодоход 1 бүтээлд олгох төлбөр нь 150,000 төгрөгөөс бага бол 1 бүтээлийн төлбөрийн доод хэмжээ 150,000₮ гэж тооцно. 5-аас дээш минутын урттай хөгжмийн бүтээлийн ашигласны төлбөрт нэмэлт 5 минут тутамд 150,000 төгрөг нэмж тооцно.
2.2.5	Дуу хөгжмийн боловсрол олгох тайлбар текст бүхий сурах бичиг хэвлэн нийтлэж нийтэд түгээх	Борлуулалтын үнийн 6 % $\times$ нийт хэвлэгдсэн тоо $\div$ нийт бүтээлийн тоо $\times$ MOSCAP бүтээлийн тоо Дээрх аргаар бодоход 1 бүтээлд олгох төлбөр нь

		150,000 төгрөгөөс бага бол 1 бүтээлийн төлбөрийн хамгийн доод хэмжээ 150,000₮ гэж тооцно.
2.2.6	Дижитал платформд хөгжмийн нот, үг нийтэлж нийтэд хүргэх	(Татан авалтын орлогын 10% ÷ нийт бүтээлийн тоо) × MOSCAP бүтээлийн тоо

Нийгэмлэгийн бүх гишүүдийн 5-р чуулганаар 2026 оны 4 сарын 2ны өдөр баталсан хөгжмийн үгтэй болон үггүй бүтээлийг ашиглалтын төлбөрийн хэмжээний талаарх гишүүд ба хөгжим хэрэглэгчдийн асуулт, санал, шаардлагыг info@moscap.mn licensing@moscap.mn хаягаар бичгээр хүлээн авна. Утас 72023999 99063796